

Өмнөх үг

Монгол Улс мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоогоо хувийн хэвшил давамгайлсан эдийн засгийн тогтвортой хөгжилд шаардагдах мэргэжил, мэргэшилтэй ажиллах хүч бэлтгэж чаддаг, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд түшиглэж ажилладаг үр өгөөжтэй тогтолцоо болгож төлөвшүүлэх зорилгыг 1990-ээд оны сүүлчээр дэвшүүлэн тавьж олон улсын хамтын нийгэмлэг, хандивлагч, дэмжигч улс орнуудын туслалцаатайгаар идэвхтэй хэрэгжүүлж байна.

Үүний зэрэгцээ хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлого хэрэгжүүлж, ажилгүйчүүд, ажил эрхлэхэд бэрхшээлтэй байгаа иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрөл бүрийн үйлчилгээ, хөтөлбөр хэрэгжүүлж ирсэн билээ.

Мөн хувийн хэвшлийн хөгжил, юуны өмнө хүн хүчний хэрэгцээгээ төлөвлөх, таамаглах, ажиллах хүчээ бүрдүүлэх, давтан сургаж, тасралтгүй хөгжүүлэх, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудтай нягт хамтран ажиллах, түншлэл, хамтын ажиллагааг дэмжих шаардлага бий болсон. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчоос тавьж буй шаардлагыг илэрхийлэх ажлын байрны захиалга, шинэ ажлын байрны тухай мэдээ, ажлын байрны тодорхойлолт, ажил мэргэжлийн лавлах, ажиллах хүчний хэрэгцээ тооцоход хэрэглэх хөдөлмөрийн норм, норматив, үндсэн цалин, хөдөлмөрийн хөлсний хэмжээ гэх мэт баримт бичгүүдийг ч зах зээлийн нөхцөлд нийцүүлж боловсруулан гаргаж ирлээ.

Ажилтанд тавигдаж буй орчин үеийн шаардлагыг мэргэжил, мэргэшлийн түвшин бүрээр боловсруулж гаргах нь ажил олгогчид, тэдгээрийн эвлэлдэн нэгдэж байгуулсан мэргэжлийн холбоо, ассоциаци, нийгэмлэгийн гол үүргийн нэг болж байна.

Зах зээлийн өндөр хөгжилтэй улс орнуудад хүмүүн нөөцийг хөгжүүлэх, үүний дотор мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаас сургалтын хөтөлбөр боловсруулахад ашиглахын тулд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээг дэлгэрэнгүй тайлбарлан бичсэн баримт бичгийг боловсруулдаг болжээ. Эдгээр баримт бичгийг дэлхийн улс орнууд өөр өөрийнхөөрөө нэрлэдэг. Жишээлбэл, Их Британид "Occupational standart", Францад "Referentiels", Германд "Ausbildungsordnung" гэх мэтээр энэхүү баримт бичгийг "Ажил мэргэжлийн лавлах" хэмээн нэрлэх нь зохистой гэж үзсэн болно. Мэргэжлийн холбоо, ассоциаци, нийгэмлэгүүдэд энэ үүргээ биелүүлэхэд мэргэжил, арга зүйн туслалцаа, санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор "Монгол Улсын Баруун бүсийн Мэргэжлийн боловсрол, сургалт" Төслөөс Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоотой хамтран хамгийн их эрэлттэй байгаа 20 мэргэжлээр ажил мэргэжлийн лавлах боловсруулж баталж гаргах, хэвлүүлэхэд туслах ажлыг зохион байгуулсан юм.

"Хүнсний үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засварчин" мэргэжлээр ажил мэргэжлийн лавлахыг үндэсний түвшний зөвлөх мэргэжилтэн, инженер, технологич, томоохон компанийн өндөр мэргэжил, мэргэшилтэй ажилтнууд мэдлэг, ур чадвар, туршлага, хандлага, үйл ажиллагааныхаа практикт

тулгуурлан II-VI түвшинтэйгээр боловсруулж баталсныг энэхүү товхимолд эмхэтгэн хэвлүүлэв.

Ажил мэргэжлийн лавлахыг холбогдох түвшин бүрээр дараах нийтлэг агуулгатайгаар боловсруулж баталсан:

- 1.Ажлын байрны товч тодорхойлолт;
- 2.Ажлын байрны тухай мэдээлэл;
 - 2.1.Ажлын байрны нөхцөл, тавигдах шаардлага;
 - 2.2.Хөдөлмөр эрхлэлт, тавигдах шаардлага;
 - 2.3.Удирдлага;
 - 2.4.Мэргэжил дээшлүүлэх, хувиараа хөдөлмөр эрхлэх боломж;
 - 2.5.Үүрэг (Ү), ажилбар (А)-ын жагсаалт.

Ажил мэргэжлийн лавлахыг ажил олгогчид нь ажлын байрны тодорхойлолт, компанийн дотоодод дагаж мөрдөх бусад баримт бичиг боловсруулахад, түр сургалтын байгууллага, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, политехник коллеж, түүнчлэн холбогдох их, дээд сургуулиуд нь сургалтын хөтөлбөрөө шинэчлэх, төгсөгчдийн үнэлгээ хийх, багш нарыг сургаж бэлтгэх, тэдний мэргэшлийг дээшлүүлэх зэрэг үйл ажиллагаандаа хэрэглэнэ.

АГУУЛГА

Ажил мэргэжлийн лавлах. Хүнсний үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засварчин (II түвшин)

Ажил мэргэжлийн лавлах. Хүнсний үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засварчин (III түвшин)

Ажил мэргэжлийн лавлах. Хүнсний үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засварчин (IV түвшин)

Ажил мэргэжлийн лавлах. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн техникч (V түвшин)

Ажил мэргэжлийн лавлах. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн техникч (VI түвшин)

Тэмдэглэл

АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ. ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАРЧИН (II ТҮВШИН)

1. Ажлын байрны тодорхойлолт

Аж ахуйн нэгж, байгууллагын засварчин нь өндөр түвшний засварчин механикийн удирдлаганд слесарийн гар багажаар хуурайдах, хөрөөдөх, таслах, өнгөлж зүлгэх зэрэг ажилбаруудыг гүйцэтгэнэ. Засвар үйлчилгээ хийгдэх тоног төхөөрөмжийн нарийн төвөгшилгүй хэсгүүдийг зааврын дагуу задална. Задалсан тоног төхөөрөмжийн эд ангиудыг цэвэрлэж ялган танина. Тухайн үйлдвэрийн технологийн анхан шатны мэдлэгтэй байна.

Монгол улсын үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт /ҮАМАТ/ дахь мэргэжлийн индекс код	
Олон улсын ажил мэргэжлийн ангилал (13СО-08) дахь код	7233-18
Боловсруулсан огноо	2016.06.20
Баталсан байгууллага	
Баталсан огноо	
Хянан засварлах хугацаа	3 жил тутам

2. Ажлын байрны тухай мэдээлэл

2.1 Ажлын байрны нөхцөл, тавигдах шаардлага

- Метал хийцийн үйлдвэрлэл, бүх төрлийн хүнсний үйлдвэр, бусад салбарын өмчийн бүх хэвшлийн байгууллага аж ахуйн нэгжийн гадна ба доторх ажлын байранд ажиллана.
- Ажлын байранд зориулалтын даавуун хувцас, төмөр хамгаалалттай гутал, малгай, маск, бээлий, хамгаалалтын нүдний шил, өндөрт ажиллах үед хамгаалалтын бүс зэрэг бие хамгаалах хэрэгсэл болон ажлын тусгай хувцас ашиглана.
- Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан байхаас гадна цэвэрлэгээ ариутгалын бодисоор хангана.
- Хувцас солих болон ариун цэврийн өрөө, усанд орох шүршүүр, хооллох ба амрах байртай байна.
- Гадаа ажиллах үед зөөврийн ажлын байраар хангана.
- Галын аюулгүй ажиллагааг хангасан манаачтай байна.

- Тэсэрч дэлбэрэх зүйлтэй харьцахдаа хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрмийг чанд сахих /хийтэй баллон, бензинээр ажилладаг тоноглол/

2.2. Хөдөлмөр эрхлэлт, тавигдах шаардлага

2.2.1. Албан боловсрол

- Суурь болон бүрэн бус, бүрэн дунд боловсролтой
- Богино хугацааны сургалт, эсвэл албан бус сургалтанд хамрагдаж ажлын талбарт дадлагажсан.

2.2.2. Эрүүл мэндийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт 6 сард нэг удаа заавал орох

2.2.3. Мэдлэг

М.1 Метал судлалын тухай товч ойлголт

М.2 Гангийн ангилал, шинж чанар, зориулалт, төрөл

М.3 Слесарийн хуурайг ашиглах, хуурайдах техник

М.4 Слесарийн хөрөөг ашиглах, хөрөөдөх техник

М.5 Металыг тэгшлэх багаж хэрэгсэл, алхыг ашиглах үеийн ХАБ-ын шаардлага

М.6 Тоног төхөөрөмжийг засварт хүлээж авах, цэвэрлэх

М.7 Түлхүүр, торцовыг зориулалтын дагуу ашиглах

М.8 Тоног төхөөрөмжийг задлах аргачлал

М.9 Цахилгаан техникийн үндэс

2.2.4. Ур чадвар

УЧ.1 Хөдөлмөрлөх насанд хүрсэн, хуулийн өмнө хариуцлага хүлээх

УЧ.2 Ажилдаа хурдан дадлагажих

УЧ.3 Хөдөлмөрлөх эв дүй, арга барилд хурдан суралцах

УЧ.4 Ажлын ачаалал даах

УЧ.5 Багаар ажиллах

УЧ.6 Слесарийн гар багажтай аюулгүй ажиллах

УЧ.7 Тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлтүүдийг уншиж ойлгох

УЧ.8 Засварын ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах

2.2.5. Хандлага

Х.1 Ажлаа амжилттай гүйцэтгэх хүсэл тэмүүлэлтэй

Х.2 Мэдлэг, мэргэжлийн хувьд өсч дэвших чин хүсэлтэй

Х.3 Тогтвор суурьшилтай ажиллах

Х.4 Хамт олны дунд биеэ зөв авч явах

Х.5 Цаг баримтлах

2.3 Удирдлага

Хэний удирдлага дор ажиллах	Ажлын удирдагч
Хэнийг удирдан ажиллах	Байхгүй

2.4. Мэргэжил дээшлүүлэх, хувиараа хөдөлмөр эрхлэх боломж

Холбогдох албан тушаалтнууд	Хөгжих дэвших боломж			Тусгай тэмдэглэл
	Бага	дунд	Өндөр	
Гүйцэтгэх албан тушаал			х	
Удирдах албан тушаал				Байхгүй
Өөр төрлийн ажил, үүрэг гүйцэтгэх боломж				Байхгүй
Хувиараа хөдөлмөр эрхлэх	х			

2.5. Үүрэг (Ү), ажилбар (А)-ын жагсаалт

Үүрэг	Ажилбар
Ажлын бэлтгэл	<ol style="list-style-type: none">1. Хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, бие хамгаалах хэрэгслийг зааврын дагуу бүрэн өмсөж хэрэглэх (шатдаггүй бөх даавуун материалтай хувцас, бээлий, маск, хамгаалалтын нүдний шил, төмөр хамгаалалттай гутал гэх мэт)2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал эрхэлсэн ажилтнаас ажлын байрны анхан шатны зааварчилгааг өдөр бүр авч гарын үсэг зурах3. Слесарийн гар багажийг ажилд бэлтгэх4. Түлхүүр, торцовыг ажилд бэлтгэх5. Засварт хүлээж авах тоног төхөөрөмжийг механик цехэд байрлуулж задлахад бэлэн болгох
Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа	<ol style="list-style-type: none">1. Засвар хийх тоног төхөөрөмжид цэвэрлэгээ хийх2. Засвар хийх тоног төхөөрөмжийн нарийн төвөгшилгүй хийцийг задлах3. Засварын ажилд шаардлагатай слесарийн үйлдлийг гүйцэтгэх4. Задарсан тоног төхөөрөмжийн эд ангийг задаргааны дагуу ялгаж тавих

Ажил дуусгах	1. Ашигласан багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хураах 2. Ажлын байрыг цэвэрлэх 3. Хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, бие хамгаалах хэрэгслийг тайлж ажлын шкафанд хураах
Ажлын гүйцэтгэлээ мэдээлэх	1. Өдөрт хийсэн ажлын биелэлтийг гаргаж тайлагнах 2. Хийсэн ажлаа дүгнүүлэх 3. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, осол гэмтэлгүй ажилласнаа мэдэгдэх

АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ. ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАРЧИН (III ТҮВШИН)

1. Ажлын байрны тодорхойлолт

Аж ахуйн нэгж, байгууллагын засварчин нь энгийн тэмдэглэгээтэй ажлын зургийг уншдаг, тоног төхөөрөмжийн үндсэн зангилаа, машин механизм, өргөх, тээвэрлэх хэрэгслийн зориулалт, зохион байгуулалт, ажиллах зарчмыг мэдэж инженер техникийн ажилтны шууд бус хяналтанд задаргаа үйлчилгээ хийнэ. Цахилгаан гар багажуудыг дээд түвшний удирдлагын шууд бус хяналтан доор ашиглана. Хөдөлмөрийн аюулгүй байдлын норм, дүрэм, эрүүл ахуй, гоо зүйн шаардлагуудыг дагаж мөрддөг байна.

Монгол улсын үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт /ҮАМАТ/ дахь мэргэжлийн индекс код	
Олон улсын ажил мэргэжлийн ангилал (13СО-08) дахь код	7233-18
Боловсруулсан огноо	2016.06.20
Баталсан байгууллага	
Баталсан огноо	
Хянан засварлах хугацаа	3 жил тутам

2. Ажлын байрны тухай мэдээлэл

2.1 Ажлын байрны нөхцөл, тавигдах шаардлага

- Метал хийцийн үйлдвэрлэл, бүх төрлийн хүнсний үйлдвэр, бусад салбарын өмчийн бүх хэвшлийн байгууллага аж ахуйн нэгжийн гадна ба доторх ажлын байранд ажиллана.
- Ажлын байранд зориулалтын даавуун хувцас, төмөр хамгаалалттай гутал, малгай, маск, бээлий, хамгаалалтын нүдний шил, өндөрт ажиллах үед хамгаалалтын бүс зэрэг бие хамгаалах хэрэгсэл болон ажлын тусгай хувцас ашиглана.
- Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан байхаас гадна цэвэрлэгээ ариутгалын бодисоор хангана.
- Хувцас солих болон ариун цэврийн өрөө, усанд орох шүршүүр, хооллох ба амрах байртай байна.
- Гадаа ажиллах үед зөөврийн ажлын байраар хангана.
- Галын аюулгүй ажиллагааг хангасан манаачтай байна.
- Тэсэрч дэлбэрэх зүйлтэй харьцахдаа хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрмийг чанд сахих /хийтэй баллон, бензинээр ажилладаг тоноглол/

2.2. Хөдөлмөр эрхлэлт, тавигдах шаардлага

2.2.1. Албан боловсрол

- Суурь болон бүрэн бус, бүрэн дунд боловсролтой
- МСҮТ, коллежид сурч төгссөн үнэмлэх гэрчилгээтэй байх

2.2.2. Эрүүл мэндийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт 6 сард нэг удаа заавал орох

2.2.3. Мэдлэг

М.1 Техникийн эскиз зураг унших

М.2 Метал боловсруулах слесарь, дарханы ажлын үндсэн төрөл

М.3 Эрээс татах арга барил, багаж хэрэгсэл

М.4 Тоног төхөөрөмжид үйлчилгээ хийх арга барил

М.5 Эд ангийг сэргээн засварлах, суурилуулах

М.6 Тоног төхөөрөмжийн бүтэц зохион байгуулалт

М.7 Штанген хэмжих хэрэгслийн төрөл, зориулалт

М.8 Машин тоног төхөөрөмжийг өргөж тээвэрлэх механизм, түүний зориулалт, ажиллах зарчим

М.9 Араан дамжуулга, түүний төрөл

М.10 Оосрон дамжуулга, түүний төрөл

М.11 Гинжин дамжуулга, түүний хэрэглээ

М.12 Метал боловсруулах суурь машины бүтэц зохион байгуулалт, ажиллагаа, төрөл ангилал (харуул, нугалах)

М.13 Тос, тосолгооны материалын төрөл ангилал, үүрэг зориулалт

М.14 Хий, шингэний системийн үндэс

М.15 Гагнуурын төрөл ангилал, тоног төхөөрөмж

2.2.4. Ур чадвар

УЧ.1 Багаар ажиллах

УЧ.2 Техникийн энгийн шугам зураг унших

УЧ.3 Слесарийн ажлыг бүрэн гүйцэтгэх

УЧ.4 Дарханы ажлыг гүйцэтгэх

УЧ.5 Цахилгаан гар багаж ашиглах

УЧ.6 Тоног төхөөрөмжид техникийн үйлчилгээ хийх

УЧ.7 Тоног төхөөрөмжид задаргаа хийх

УЧ.8 Тоног төхөөрөмжийн схем, паспортыг уншиж ойлгодог байх

2.2.5. Хандлага

Х.1 Мэргэжилдээ дур сонирхолтой

Х.2 Бусдын шийдвэрийг хүндэтгэх

Х.3 Бусдад туслах эрмэлзэлтэй

Х.4 Тэвчээр хатуужилтай

Х.5 Өөртөө итгэлтэй

Х.6 Суралцах болон мэргэжлээ дээшлүүлэх хүсэлтэй

Х.7 Цаг баримтлах

2.3 Удирдлага

Хэний удирдлага дор ажиллах	Ажлын удирдагч
Хэнийг удирдан ажиллах	Байхгүй

2.4. Мэргэжил дээшлүүлэх, хувиараа хөдөлмөр эрхлэх боломж

Холбогдох албан тушаалтнууд	Хөгжих дэвших боломж			Тусгай тэмдэглэл
	Бага	дунд	Өндөр	
Гүйцэтгэх албан тушаал			х	
Удирдах албан тушаал				Байхгүй

Өөр төрлийн ажил, үүрэг гүйцэтгэх боломж				Байхгүй
Хувиараа хөдөлмөр эрхлэх	х			

2.5. Үүрэг (Ү), ажилбар (А)-ын жагсаалт

Үүрэг	Ажилбар
Ажлын бэлтгэл	<ol style="list-style-type: none"> 1. Хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, бие хамгаалах хэрэгслийг зааврын дагуу бүрэн өмсөж хэрэглэх (шатдаггүй бөх даавуун материалтай хувцас, бээлий, маск, хамгаалалтын нүдний шил, төмөр хамгаалалттай гутал гэх мэт) 2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал эрхэлсэн ажилтнаас ажлын байрны анхан шатны зааварчилгааг өдөр бүр авч гарын үсэг зурах 3. Засварыг ажлын байрыг оновчтой зохион байгуулах 4. Эд ангийг механик аргаар сэргээн засварлах багаж хэрэгслийг бэлтгэх 5. Төрөл бүрийн хэмжээст түлхүүр, торцовны иж бүрдлийг ажилд бэлтгэх 6. Цахилгаан гагнуурыг ажилд бэлтгэх 7. Өргөж тээвэрлэх хэрэгслийг ажилд бэлтгэх
Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа	<ol style="list-style-type: none"> 1.Засвар хийх тоног төхөөрөмжийг зааврын дагуу задлах 2. Тоног төхөөрөмжид гарсан гэмтлийг мэдрэхүйн эрхтэний тусламжтайгаар шалгах 3. Тоног төхөөрөмжийн цахилгааны гэмтлийг цахилгаанчинд мэдээллэх
Ажил дуусгах	<ol style="list-style-type: none"> 1. Ашигласан багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хураах 2. Ажлын байрыг цэвэрлэх 3. Хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, бие хамгаалах хэрэгслийг тайлж ажлын шкафанд хураах
Ажлын гүйцэтгэлээ мэдээлэх	<ol style="list-style-type: none"> 1. Өдөрт хийсэн ажлын биелэлтийг гаргаж тайлагнах 2. Хийсэн ажлаа дүгнүүлэх 3. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, осол

АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ. ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАРЧИН (IV ТҮВШИН)

1. Ажлын байрны тодорхойлолт

Аж ахуйн нэгж, байгууллагын засварчин нь ажлын зураг, төслийн өгөгдөл, тэмдэглэгээг уншиж, гэмтэл саатлын шалтгааныг олж засварын үндсэн аргуудаас тохирох аргыг дээд түвшний удирдлагад санал болгоно. Доод түвшний ажилтанд хяналт тавьж чиглүүлэхээс гадна тоног төхөөрөмжийн цахилгааны болон механик гэмтлийг оношилж засварлана. Метал боловсруулах суурь машины бүтэц зохион байгуулалтыг мэддэг, цахилгаан гар багажуудыг ажиллуулж бүрэн ашиглана. Цахилгаан ба хийн гагнуураар төвөгшил багатай хийцийг хэвтээ байрлалд гагнана.

Монгол улсын үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт /YAMAT/ дахь мэргэжлийн индекс код	
Олон улсын ажил мэргэжлийн ангилал (13CO-08) дахь код	7233-18
Боловсруулсан огноо	2016.06.20
Баталсан байгууллага	
Баталсан огноо	
Хянан засварлах хугацаа	3 жил тутам

2. Ажлын байрны тухай мэдээлэл

2.1 Ажлын байрны нөхцөл, тавигдах шаардлага

- Метал хийцийн үйлдвэрлэл, бүх төрлийн хүнсний үйлдвэр, бусад салбарын өмчийн бүх хэвшлийн байгууллага аж ахуйн нэгжийн гадна ба доторх ажлын байранд ажиллана.
- Ажлын байранд зориулалтын даавуун хувцас, төмөр хамгаалалттай гутал, малгай, маск, бээлий, хамгаалалтын нүдний шил, гагнуурын баг өндөрт ажиллах үед хамгаалалтын бүс зэрэг бие хамгаалах хэрэгсэл болон ажлын тусгай хувцас ашиглана.

- Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан байхаас гадна цэвэрлэгээ ариутгалын бодисоор хангана.
- Хувцас солих болон ариун цэврийн өрөө, усанд орох шүршүүр, хооллох ба амрах байртай байна.
- Гадаа ажиллах үед зөөврийн ажлын байраар хангана.
- Галын аюулгүй ажиллагааг хангасан манаачтай байна.
- Тэсэрч дэлбэрэх зүйлтэй харьцахдаа хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрмийг чанд сахих /хийтэй баллон, бензинээр ажилладаг тоноглол/

2.2. Хөдөлмөр эрхлэлт, тавигдах шаардлага

2.2.1. Албан боловсрол

- Суурь болон бүрэн бус, бүрэн дунд боловсролтой
- МСҮТ, коллежид сурч төгссөн үнэмлэх гэрчилгээтэй байх

2.2.2. Эрүүл мэндийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт 6 сард нэг удаа заавал орох

2.2.3. Мэдлэг

М.1 Ажлын зураг, төслийн өгөгдөл, тэмдэглэгээ

М.2 Тоног төхөөрөмжийн техникийн үндсэн үзүүлэлтүүд

М.3 Засварын ажилд хэрэглэх хэмжих, шалгах багаж хэрэгсэл

М.4 Техникийн эд анги, зангилаа

М.5 Микро хэмжих багаж, түүний төрөл

М.6 Нүхлэх үйлдэл, нүхний боловсруулалтын багажны төрөл

М.7 Гадна дотор эрээс татах багаж хэрэгсэл

М.8 Тэвхэн болон эрээсэн холбоос

М.9 Өрмийн суурь машины бүтэц, зохион байгуулалт, төрөл ангилал

М.10 Точилийн суурь машины бүтэц, зохион байгуулалт, төрөл ангилал

М.11 Метал боловсруулах суурь машины бүтэц зохион байгуулалт, ажиллагаа, төрөл ангилал (токарь, фрезер, пресс)

М.12 Автоматикийн үндсэн хэрэгсэл, үзүүлэлтүүд

М.13 Гидравлик системийн тухай үндсэн ойлголт, хэрэглээ

М.14 Хийн системийн тухай үндсэн ойлголт, хэрэглээ

М.15 Цахилгаан гүйдэл, гүйдлийн төрөл

М.16 Тухайн үйлдвэрлэлийн технологи

2.2.4. Ур чадвар

УЧ.1 Багаар ажиллах

УЧ.2 Ажлын зураг, тэмдэглэгээг уншиж, зургийн дагуу ажиллах

УЧ.3 Тоног төхөөрөмжид гарсан бага зэргийн механик гэмтэлд магадлал тогтоох

УЧ.4 Тоног төхөөрөмжийн цахилгааны энгийн гэмтлийг тодорхойлох

УЧ.5 Машин тоног төхөөрөмжийн хийц, бүтэц зохион байгуулалтыг доод түвшний дагалдан засварчдад тайлбарлах

УЧ.6 Цахилгаан гагнуураар энгийн төвөгшил багатай хийц гагнах

УЧ.7 Токарийн суурь машинаар эд анги, хийцэд механик боловсруулалт хийх

УЧ.8 Тухайн үйлдвэрлэлийн технологитой уялдуулан тоног төхөөрөмжийн гэмтлийг магадлах

2.2.5. Хандлага

Х.1 Мэргэжилдээ дур сонирхолтой

Х.2 Сахилга баттай найдвартай

Х.3 Бусдын шийдвэрийг хүндэтгэх

Х.4 Бусдад туслах эрмэлзэлтэй

Х.5 Тэвчээр хатуужилтай

Х.6 Өөртөө итгэлтэй

Х.7 Суралцах болон мэргэжлээ дээшлүүлэх хүсэл, тэмүүлэлтэй

Х.8 Цаг баримтлах

2.3 Удирдлага

Хэний удирдлага дор ажиллах	Ажлын удирдагч
Хэнийг удирдан ажиллах	Байхгүй

2.4. Мэргэжил дээшлүүлэх, хувиараа хөдөлмөр эрхлэх боломж

Холбогдох албан тушаалтнууд	Хөгжих дэвших боломж			Тусгай тэмдэглэл
	Бага	дунд	Өндөр	
Гүйцэтгэх албан тушаал			х	
Удирдах албан тушаал				Байхгүй
Өөр төрлийн ажил, үүрэг гүйцэтгэх боломж				Гагнуурчнаар ажиллах
Хувиараа хөдөлмөр эрхлэх	х			

2.5. Үүрэг (Ү), ажилбар (А)-ын жагсаалт

Үүрэг	Ажилбар
Ажлын бэлтгэл	<ol style="list-style-type: none">1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал эрхэлсэн ажилтнаас ажлын байрны анхан шатны зааварчилгааг өдөр бүр авч гарын үсэг зурах2. Шаардлагатай үед өдөр бүр зааварчилгаа авах3. Засварын ажлын төлөвлөгөөний дагуу ажлын байр, багаж хэрэгслээ бэлтгэх4. Тухайн засварлах тоног төхөөрөмжийг задлахад шаардлагатай багаж хэрэгслийг сонгох5. Металыг тайрах суурин машиныг ажилд бэлтгэх6. Метал боловсруулах суурь машиныг ажилд бэлтгэх
Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа	<ol style="list-style-type: none">1. Тоног төхөөрөмжид гарсан гэмтлийг оношлох2. Тоног төхөөрөмжийн цахилгаан гэмтлийг хэмжих хэрэгсэл ашиглан шалгах3. Тоног төхөөрөмжийн эд ангийг метал боловсруулах суурь машин дээр боловсруулах4. Машин тоног төхөөрөмжийн элэгдсэн, хугарсан эд ангийг сэлбэгийн эд ангиар орлуулан засварлах5. Засварлагдсан машин тоног төхөөрөмжийг угсарч ажиллагаанд оруулах
Ажил дуусгах	<ol style="list-style-type: none">1. Ашигласан багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хураах2. Ажлын байрыг цэвэрлэх3. Хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, бие хамгаалах хэрэгслийг тайлж ажлын шкафанд хураах
Ажлын гүйцэтгэлээ мэдээлэх	<ol style="list-style-type: none">1. Өдөрт хийсэн ажлын биелэлтийг гаргаж тайлагнах2. Хийсэн ажлаа дүгнүүлэх3. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, осол гэмтэлгүй ажилласнаа мэдэглэх

АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ. ҮЙЛДВЭРИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТЕХНИКЧ (V ТҮВШИН)

1. Ажлын байрны тодорхойлолт

Аж ахуйн нэгж, байгууллагын засварчин нь машин тоног төхөөрөмжийн засварын ажлын төлөвлөгөө гаргаж, засварлах ажлыг удирдан зохион байгуулах буюу бие даан засварлана. Засварын ажилтай холбоотой зураг төсөл боловсруулж, шаардлагатай сэлбэг материал зардлын тооцоо гаргана. Машин тоног төхөөрөмжийг шинээр угсарч суурилуулахад дээд удирдлагаас заавар зөвлөгөө авч засварчдыг удирдан чиглүүлж ажиллана. Машин тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, суурилуулалтын ажилд өөрийн онолын мэдлэг, ур чадварыг хослуулан оновчтой шийдлийг гаргана. Машин тоног төхөөрөмжийн засвар суурилуулалтын ажилд шаардлагатай цахилгаан нуман гагнуурыг орон зайн бүх байрлалд гүйцэтгэнэ.

Монгол улсын үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт /ҮАМАТ/ дахь мэргэжлийн индекс код	
Олон улсын ажил мэргэжлийн ангилал (13СО-08) дахь код	7233-18
Боловсруулсан огноо	2016.06.20
Баталсан байгууллага	
Баталсан огноо	
Хянан засварлах хугацаа	3 жил тутам

2. Ажлын байрны тухай мэдээлэл

2.1 Ажлын байрны нөхцөл, тавигдах шаардлага

- Метал хийцийн үйлдвэрлэл, бүх төрлийн хүнсний үйлдвэр, бусад салбарын өмчийн бүх хэвшлийн байгууллага аж ахуйн нэгжийн гадна ба доторх ажлын байранд ажиллана.
- Ажлын байранд зориулалтын даавуун хувцас, төмөр хамгаалалттай гутал, малгай, маск, бээлий, хамгаалалтын нүдний шил, өндөрт ажиллах үед хамгаалалтын бүс зэрэг бие хамгаалах хэрэгсэл болон ажлын тусгай хувцас ашиглана.
- Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан байхаас гадна цэвэрлэгээ ариутгалын бодисоор хангана.

- Хувцас солих болон ариун цэврийн өрөө, усанд орох шүршүүр, хооллох ба амрах байртай байна.
- Гадаа ажиллах үед зөөврийн ажлын байраар хангана.
- Галын аюулгүй ажиллагааг хангасан манаачтай байна.
- Тэсэрч дэлбэрэх зүйлтэй харьцахдаа хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрмийг чанд сахих /хийтэй баллон, бензинээр ажилладаг тоноглол/

2.2. Хөдөлмөр эрхлэлт, тавигдах шаардлага

2.2.1. Албан боловсрол

- Суурь болон бүрэн бус, бүрэн дунд боловсролтой
- МСҮТ, коллежид сурч төгссөн үнэмлэх гэрчилгээтэй байх

2.2.2. Эрүүл мэндийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт 6 сард нэг удаа заавал орох

2.2.3. Мэдлэг

М.1 Металын физик химийн шинж чанар

М.2 Металын механик болон технологийн шинж чанар

М.3 Металын механик боловсруулалт

М.4 Металын дулааны боловсруулалт

М.5 Дамжуулгын кинематик схем

М.6 Механизмын тухай ойлголт нугасан болон хөшүүрэгт механизм

М.7 Араат болон үрлэн механизм

М.8 Нударгат болон уян мөчит механизм

М.9 Цахилгааны цуваа, зэрэгцээ, одон холболт тэдгээрийн онцлог

М.10 Индикаторт хэмжих шалгах багаж, түүний ашиглалт

М.11 Тоног төхөөрөмжийн оношлогооны тоног төхөөрөмж, түүний хэрэглээ

М.12 Тоног төхөөрөмжийн агааржуулалтын систем

2.2.4. Ур чадвар

УЧ.1 Шинийг санаачлах, шийдвэр гаргах

УЧ.2 Зохион байгуулах, төлөвлөх

УЧ.3 Багаар ажиллах

УЧ.4 Техникийн болон гагнуурын зургийг унших

УЧ.5 Металд дулааны болон механик боловсруулалт хийх

УЧ.6 Металын шинж чанарыг метал хийц, метал боловсруулалтад тохируулан ашиглах

УЧ.7 Машин тоног төхөрөөрөмжийн эвдрэл гэмтлээс үл хамааран бие даан шинжилгээ хийж, шийдвэр гаргах

УЧ.8 Шинэ тоног төхөөрөмжийг угсрах

УЧ.9 Цахилгаан нуман гагнуураар нарийн төвөгтэй хийцийг гагнах

2.2.5. Хандлага

Х.1 Ажлын харилцаанд биеэ зөв авч явах

Х.2 Бусдыг хүндлэх, эелдэг харьцах

Х.3 Бусдад туслах эрмэлзэлтэй

Х.4 Доод түвшний ажилчдаа өмгөөлж хамгаалах

Х.5 Бусдын шийдвэрийг хүндэтгэх

Х.6 Цаг баримтлах

Х.7 Ёс зүйтэй байх

2.3 Удирдлага

Хэний удирдлага дор ажиллах	Ажлын удирдагч
Хэнийг удирдан ажиллах	Байхгүй

2.4. Мэргэжил дээшлүүлэх, хувиараа хөдөлмөр эрхлэх боломж

Холбогдох албан тушаалтнууд	Хөгжих дэвших боломж			Тусгай тэмдэглэл
	Бага	дунд	Өндөр	
Гүйцэтгэх албан тушаал			х	
Удирдах албан тушаал				Байхгүй
Өөр төрлийн ажил, үүрэг гүйцэтгэх боломж				Гагнуурчнаар ажиллах
Хувиараа хөдөлмөр эрхлэх	х			

2.5. Үүрэг (Ү), ажилбар (А)-ын жагсаалт

Үүрэг	Ажилбар
Ажлын бэлтгэл	Доод түвшний засварчдын багаж хэрэгслийг бэлтгүүлэх. 1. Слесарийн хуурай, хөрөө, хасуур алхыг ажилд бэлтгэх 2. Бахь, францус, отвёртка, газовыг ажилд бэлтгэх 3. Түлхүүрийн иж бүрдлийг ажилд бэлтгэх 4. Торцов, тусгай түлхүүрийн иж бүрдлийг ажилд

	<p>бэлтгэх</p> <p>5. Цахилгаан гар багажийг ажилд бэлтгэх</p> <p>6. Цахилгаан гагнуурын төхөөрөмжийг ажилд бэлтгэх</p>
<p>Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа</p>	<p>1. Тоног төхөөрөмжид гарсан гэмтлийг оношлох</p> <p>2. Тоног төхөөрөмжийн цахилгаан гэмтлийг хэмжих хэрэгсэл ашиглан шалгах</p> <p>3. Тоног төхөөрөмжийн эд ангийг метал боловсруулах суурь машин дээр боловсруулах</p> <p>4. Машин тоног төхөөрөмжийн элэгдсэн, хугарсан эд ангийг сэлбэгийн эд ангиар орлуулан засварлах</p> <p>5. Засварлагдсан машин тоног төхөөрөмжийг угсарч ажиллагаанд оруулах</p> <p>6. Шинэ тоног төхөөрөмжийг технологи дарааллын дагуу угсрах</p> <p>7. Шинээр угсрагдсан тоног төхөөрөмжийг тохирох газарт нь суурилуулах</p>
<p>Ажил дуусгах</p>	<p>1. Ашигласан багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хураах</p> <p>2. Ажлын байрыг цэвэрлэх</p> <p>3. Хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, бие хамгаалах хэрэгслийг тайлж ажлын шкафанд хураах</p>
<p>Ажлын гүйцэтгэлээ мэдээлэх</p>	<p>1. Өдөрт хийсэн ажлын биелэлтийг гаргаж тайлагнах</p> <p>2. Хийсэн ажлаа дүгнүүлэх</p> <p>3. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, осол гэмтэлгүй ажилласнаа мэдэглэх</p>

АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ. ҮЙЛДВЭРИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТЕХНИКЧ (VI ТҮВШИН)

1. Ажлын байрны тодорхойлолт

Аж ахуйн нэгж, байгууллагын засварчин нь машин тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээний мэргэжлийн үйл ажиллагааг нарийн төлөвлөж технологийн дагуу ажил гүйцэтгэх дарааллыг тогтоож, ажиллах хүчийг үр дүнтэй тооцоолох, хуваарилах, байршуулах, бүтээлчээр зохион байгуулах, мэргэжлийн өндөр түвшинд удирдлагаар хангах, засвар үйлчилгээний ажлын тодорхой бус нөхцөл байдал бий болсон тохиолдолд шинжлэх ухааны үндэстэй таамаг дэвшүүлэх, шийдвэрлэх арга замыг тодорхойлох техник, технологийн

мэдлэг, ур чадвартай байна. Машин тоног төхөөрөмжийг шинээр угсарч суурилуулахад мэргэжлийн өндөр түвшний заавар зөвлөгөө өгч засварчдыг удирдан чиглүүлж ажиллана. Ажлын шаардлагаар цахилгаан ба аргон нуман гагнуурын ажлыг орон зайн бүх байрлалд гүйцэтгэнэ.

Монгол улсын үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт /ҮАМАТ/ дахь мэргэжлийн индекс код	
Олон улсын ажил мэргэжлийн ангилал (13СО-08) дахь код	7233-18
Боловсруулсан огноо	2016.06.20
Баталсан байгууллага	
Баталсан огноо	
Хянан засварлах хугацаа	3 жил тутам

2. Ажлын байрны тухай мэдээлэл

2.1 Ажлын байрны нөхцөл, тавигдах шаардлага

- Метал хийцийн үйлдвэрлэл, бүх төрлийн хүнсний үйлдвэр, бусад салбарын өмчийн бүх хэвшлийн байгууллага аж ахуйн нэгжийн гадна ба доторх ажлын байранд ажиллана.
- Ажлын байранд зориулалтын даавуун хувцас, төмөр хамгаалалттай гутал, малгай, маск, бээлий, хамгаалалтын нүдний шил, өндөрт ажиллах үед хамгаалалтын бүс зэрэг бие хамгаалах хэрэгсэл болон ажлын тусгай хувцас ашиглана.
- Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан байхаас гадна цэвэрлэгээ ариутгалын бодисоор хангана.
- Хувцас солих болон ариун цэврийн өрөө, усанд орох шүршүүр, хооллох ба амрах байртай байна.
- Гадаа ажиллах үед зөөврийн ажлын байраар хангана.
- Галын аюулгүй ажиллагааг хангасан манаачтай байна.
- Тэсэрч дэлбэрэх зүйлтэй харьцахдаа хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрмийг чанд сахих /хийтэй баллон, бензинээр ажилладаг тоноглол/

2.2. Хөдөлмөр эрхлэлт, тавигдах шаардлага

2.2.1. Албан боловсрол

- Суурь болон бүрэн бус, бүрэн дунд боловсролтой
- МСҮТ, коллежид сурч төгссөн үнэмлэх гэрчилгээтэй байх

2.2.2. Эрүүл мэндийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт 6 сард нэг удаа заавал орох

2.2.3. Мэдлэг

М.1 Металын бүтцийг шинжлэн судлах аргууд

М.2 Машин тоног төхөөрөмжийг задлах технологи

М.3 Машин тоног төхөөрөмжийн гэмтэл, саатлыг оношлох аргууд

М.4 Машин засварын технологи

М.5 Тоног төхөөрөмжийг угсралт, суурилуулалт

М.6 Метал биш материалын төрөл, хэрэглээ

М.7 Тахометрийн үүрэг зориулалт, хэрэглээ

М.8 Даралтат хийн систем

М.9 Халуун уур болон усны систем

М.10 Орос, англи хэл

2.2.4. Ур чадвар

УЧ.1 Зохион байгуулах, төлөвлөх

УЧ.2 Шинийг санаачлагч, шийдвэр гаргах

УЧ.3 Багаар ажиллах

УЧ.4 Идэвхжүүлэх, урамшуулах

УЧ.5 Засвар, үйлчилгээний ажлын нарийвчилсан төлөвлөгөөний дагуу ажиллах

УЧ.6 Засварчдыг ажлын байранд оновчтой хуваарилах

УЧ.7 Засвар, үйлчилгээний ажлын төвөгтэй болон судлагдаагүй нөхцөлд байдалд шинжлэх ухааны үндэстэй таамаг гаргаж шийдвэрлэх

УЧ.8 Доод түвшний засварчдад мэргэжлийн чиглэлийн зааварчилгааг өндөр түвшинд өгөх

УЧ.9 Эд ангийн ажлын зураг гаргах

УЧ.10 Тухайн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжид гарсан гэмтлийг бие даан засварлах

УЧ.11 Гадаад хэл дээрх техникийн үзүүлэлт, тэмдэглэгээг орчуулж ашигладаг байх

УЧ.12 Тухайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг мэддэг, бусдад тайлбарладаг байх

2.2.5. Хандлага

- Х.1 Мэргэжлээрээ хүлээн зөвшөөрөгдөх
- Х.2 Ажлын харилцаанд биеэ зөв авч явах
- Х.3 Бусдыг хүндлэх, эелдэг харьцах
- Х.4 Бусдад туслах эрмэлзэлтэй
- Х.5 Доод түвшний ажилчдаа өмгөөлж хамгаалах
- Х.6 Бусдын шийдвэрийг хүндэтгэх
- Х.7 Цаг баримтлах
- Х.8 Ёс зүйтэй байх

2.3 Удирдлага

Хэний удирдлага дор ажиллах	Ажлын удирдагч
Хэнийг удирдан ажиллах	Байхгүй

2.4. Мэргэжил дээшлүүлэх, хувиараа хөдөлмөр эрхлэх боломж

Холбогдох албан тушаалтнууд	Хөгжих дэвших боломж			Тусгай тэмдэглэл
	Бага	дунд	Өндөр	
Гүйцэтгэх албан тушаал			х	
Удирдах албан тушаал				Байхгүй
Өөр төрлийн ажил, үүрэг гүйцэтгэх боломж				Гагнуурчнаар ажиллах
Хувиараа хөдөлмөр эрхлэх	х			

2.5. Үүрэг (Ү), ажилбар (А)-ын жагсаалт

Үүрэг	Ажилбар
Ажлын бэлтгэл	Доод түвшний засварчдын багаж хэрэгслийг бэлтгүүлэх. 1. Слесарийн хуурай, хөрөө, хасуур алхыг ажилд бэлтгэх 2. Бахь, францус, отвёртка, газовыг ажилд бэлтгэх 3. Түлхүүрийн иж бүрдлийг ажилд бэлтгэх 4. Торцов, тусгай түлхүүрийн иж бүрдлийг ажилд бэлтгэх 5. Цахилгаан гар багажийг ажилд бэлтгэх 6. Цахилгаан гагнуурын төхөөрөмжийг ажилд бэлтгэх

	7. Аргон нуман гагнуурын тоног төхөөрөмжийг ажилд бэлтгэх
Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа	<ol style="list-style-type: none"> 1. Засвар, үйлчилгээний ажлыг удирдан зохион байгуулах 2. Доод түвшний засварчдаар хуваарилсан ажлыг нь хийлгэж хяналт тавих 3. Тоног төхөөрөмжийн эд ангийг токарь болон фрезерийн суурь машин дээр боловсруулах 4. Машин тоног төхөөрөмжийн элэгдсэн, хугарсан эд ангийг сэлбэгийн эд ангиар орлуулан засварлах 5. Засварлагдсан машин тоног төхөөрөмжийг угсарч ажиллагаанд оруулах туршилт хийх 6. Задалж угсрахад бэрхшээлтэй төхөөрөмжид технологийн дагуу үзлэг хийх 7. Шинээр угсрагдсан тоног төхөөрөмжийн технологи дарааллыг шалгаж байрлуулах
Ажил дуусгах	<ol style="list-style-type: none"> 1. Ашигласан багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хураах 2. Ажлын байрыг цэвэрлэх 3. Хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, бие хамгаалах хэрэгслийг тайлж ажлын шкафанд хураах
Ажлын гүйцэтгэлээ мэдээлэх	<ol style="list-style-type: none"> 1. Өдөрт хийсэн ажлын биелэлтийг гаргаж тайлагнах 2. Хийсэн ажлаа дүгнүүлэх 3. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, осол гэмтэлгүй ажилласнаа мэдэглэх